

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС
БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон байдал

Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа

Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасан анхдагч хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр (Хэлэлцээр)-ийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төслийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд соёрхон батлах Хэлэлцээрт туссан дараах зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгахар сонгож авав. Үүнд:

- Хэлэлцээрийн хүрээнд нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлсэн нь хэрэгжүүлэгч субъект /нийгмийн даатгалын байгууллага, байцаагч/-д ачаалал, бэрхшээл учруулах эсэх, хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардал гарах эсэхийг үнэлэх;
- Хэлэлцээрт туссан зохицуулалтууд нь хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид нийцэж байгаа эсэхийг;
- Хэлэлцэн тохиролцогч талуудад тэтгэвэр тогтоохтой холбоотой зохицуулалт нь хоёр улсын иргэдийн харилцан тэгш эрхтэй байдлыг тусгасан эсэхийг үнэлэх;
- Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд хүний хувийн мэдээллийг дамжуулах, солилцох зохицуулалтыг үнэлэх /16 дугаар зүйл/.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг үнэлэхийг зорив.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөсөн зохицуулалттай холбогдон гарах тооцоолол хийх мөн “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хэлэлцээр, хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төсөл нь “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн

хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах эрх зүйн үндсийг тодорхойлох зорилгоор дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах;

2. Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад томилолтоор ажиллагч нь шимтгэл давхар төлөхөөс сэргийлэх;

3. Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох боломжийг бүрдүүлэх;

4. Хэлэлцэн тохиролцогч талууд тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулах.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлэхэд:

Зорилт 1. *Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар:*

Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн тоо 2023 оны байдлаар 210.0² мянга буюу нийт хүн амын 6.1 хувь байгаагаас 110.0 мянга нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Иймд одоогийн нийгмийн даатгалын тогтолцооны хамрах хүрээнээс гадуур байгаа эдгээр иргэдийг нийгмийн даатгалд хамруулах тусгайлсан зохицуулалтыг хуулиар зохицуулах шаардлагатай байгаа тул хуулийн төсөлд хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 2. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл давхар төлөхөөс сэргийлэх талаар:*

Богино хугацаагаар ажиллагч иргэд Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн хүрээнд хоёр улсад давхар шимтгэл төлөөс сэргийлэх зохицуулалтыг хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 3. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох боломжийг бүрдүүлэх талаар:*

Тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн иргэд Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийн хүрээнд ямар тэтгэврийн төрөлд хамрагдахыг тодорхой болгох, ямар хугацааны шимтгэл төлсөн хугацааг тооцох зохицуулалтыг хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 4. *Хэлэлцэн тохиролцогч талууд тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулах талаар*

Хэлэлцэн тохиролцогч талуудад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэврийг хэрхэн тогтоох, олгох харилцааг тодорхой болгох зохицуулалтыг хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

² Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээлэл

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, Сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох
2	Практикт хэрэгжих боломж	Хэлэлцээрийн 2, 4, 14, 15, 16, 17, 18, 19 дугаар зүйл	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) эсэхийг судалж тодорхойлох
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Зардал	“Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоо хийх	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлын тооцоо хийх /аргачлалын дагуу тусад нь хийх/
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зарим хэсэг	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилт 1. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар үнэлгээ хийсэн нь:

Монгол Улсын өнөөгийн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэд өөрийн улсынхаа нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах боломжтой хэдий ч тухайн амьдарч буй улсдаа давхар шимтгэл төлөх, шимтгэл төлсөн хугацаа нь Монгол Улсад даатгуулсан хугацаанд тооцогдохгүй нөхцөл байдал үүсэж байна. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэд тухайн улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдахад иргэний харьяаллын шаардлага, тэтгэвэр, тэтгэмж авах хууль тогтоомжид заасан хугацааны нөхцөл хангахгүйд хүрч нийгмийн хамгааллын баталгаа нь алдагдах,

мөн тухайн улс болон өөрийн улсдаа нийгмийн даатгалын шимтгэлийг давхар төлж санхүүгийн ачаалалд орох зэрэг бэрхшээлүүд тулгарч байна.

Энэ нь иргэд ирээдүйд бага тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн эрх үүсэхгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тиймээс Хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн хүрээнд хэлэлцэн тохиролцогч талуудын иргэд хоёр улсад ажилласан (даатгуулсан) хугацаагаа нэгтгэн тооцуулж, тэтгэвэр тогтоолгон авах зэрэг зохицуулалтыг тусгасан нь хоёр улсын иргэдийн ирээдүйн нийгмийн хамгааллын баталгааг хангахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Зорилт 2. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл давхар төлөхөөс сэргийлэх талаарх үнэлгээ:*

Хэлэлцэн тохиролцогч нэг талаас хэлэлцэн тохиролцогч нөгөө талд томилолтоор эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол зөвхөн эхний талдаа буюу өөрийн улсдаа шимтгэл төлөх харилцааг зохицуулсан байна. Энэхүү харилцааг Хэлэлцээрийн 6, 7, 8 дугаар зүйлд нарийвчлан заажээ. Тухайлбал, 6 дугаар зүйлд Ерөнхий заалтыг, 7 дугаар зүйлд Тусгай заалтууд буюу 1-60 хүртэл хугацаанд хэлэлцэн тохиролцогч нөгөө талд томилолтоор эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол давхар шимтгэл төлөхөөр сэргийлсэн зохицуулалтыг тусгасан байна.

Зорилт 3. *Хэлэлцэн тохиролцогч хоёр улсад шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох боломжийг бүрдүүлсэн байдлын үнэлгээ:*

Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомж, тэтгэврийн тогтолцооны онцлогоос хамааруулж тэтгэврийн төрлийг сонгож, хоёр улсад шимтгэл төлсөн цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож байж тэтгэвэр тогтоохоор зохицуулсан байна.

Тухайлбал, Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд тэтгэврийн төрлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Энэхүү Хэлэлцээрт дараах хууль тогтоомж хамаарна:

а) Монгол Улсын тухайд:

Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн асуудлаарх хууль тогтоомж;

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудлаарх хууль тогтоомж;

б) Бүгд Найрамдах Австри Улсын тухайд:

Нотариатчидын онцгой хамгааллаас бусад тэтгэврийн даатгалын асуудлаарх хууль тогтоомж;

Зөвхөн II бүлгийн тухайд, өвчний даатгал болон ослын даатгалын асуудлаарх хууль тогтоомж.

Мөн Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох харилцааг зохицуулжээ. Үүнд:

1.Хэрэв тухайн хүн Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацаатай бол тэтгэмж авах эрхийг тодорхойлох зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх тодорхойлох Хэлэлцэн

тохиролцогч тал нь эдгээр хугацааг өөрийн талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаа мэтээр нэгтгэн тооцно.

2.Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тусгай схемийн хүрээнд тодорхой мэргэжлийн төрөлд, эсхүл тухайлсан ажил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзан тэтгэмж олгодог бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу зөвхөн ижил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд даатгалын шимтгэл төлсөн хугацааг тухайн тэтгэмжийг олгохдоо харгалзан үзнэ.

3.Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь нийгмийн хамгааллын тухай ижил төрлийн хэлэлцээр байгуулсан гуравдагч улсад даатгалын шимтгэл төлсөн хугацааг зөвхөн Хэлэлцэн тохиролцогч тухайн тал нь тэтгэвэр олгох эрхийг тодорхойлох зорилгоор харгалзан үзнэ.

4.Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн төлбөрийг олгосон хугацаа нь даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгахаар заасан тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авсан хугацаагаар дээр дурдсан даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацааг уртасгана.

Зорилт 4. *Хэлэлцэн тохиролцогч талууд тэтгэвэр тогтоох, олгохтой холбоотой харилцааг зохицуулах талаар үнэлгээ хийсэн нь:*

Хэлэлцээрийн 10, 11 дүгээр зүйлд Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоох, 14-23 дугаар зүйлд Хэлэлцээрийн хүрээнд тэтгэврийг олгохтой холбоотой талуудын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан мэдээлэл солилцохоор зохицуулсан нь зорилгоо илэрхийлсэн гэж үнэллээ.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

1/ *Хэлэлцээрт нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлсэн нь хэрэгжүүлэгч субъект /нийгмийн даатгалын байгууллага, байцаагч/-д ачаалал, бэрхшээл учруулах эсэх, хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардлын үнэлгээ*

Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас олгох жилд дунджаар 20 орчим мянган хүн тэтгэвэр тогтоолгож байна. Бүгд Найрамдах Австри Улсад 2024 оны байдлаар Монгол Улсын 3000 орчим иргэн оршин сууж байгаагаас 1.7 мянга иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Монгол Улсад Бүгд Найрамдах Австри Улсын 30 орчим иргэн оршин сууж байна. Мөн Хэлэлцээрийг хэрэгжүүлэгч Нийгмийн даатгалын байгууллагад улсын хэмжээнд 1.5 мянган албан хаагч ажиллаж байна. Тиймээс Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсад тэтгэвэр тогтооход нийгмийн даатгалын байгууллага, байцаагчид ачаалал үүсэхгүй бөгөөд Хэлэлцээрийг Бүгд Найрамдах Австри Улсад ажилласан жилийг баталгаажуулахад шаардлагатай шуудангийн зардлаас өөр нэмэлт зардал гаргахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой.

2/ *Хэлэлцээрт туссан зохицуулалтууд нь хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид нийцэж байгаа эсэх үнэлгээ*

Хэлэлцээрийн хүрээнд тэтгэвэр тогтоох харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон Монгол Улсад шимтгэл төлөх харилцааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

Хэлэлцээрт туссан зохицуулалтууд нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 1952 онд батлан гаргасан “Нийгмийн хамгааллын доод хэмжээний тухай” 102 дугаар конвенцод³ дурдсан нийгмийн хамгааллын доод хэмжээний зөвлөмжтэй нийцэж байгаа болно.

Түүнчлэн Хэлэлцээр нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц болон 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцийн холбогдох заалтад нөлөөлөхгүй.

3/ Хэлэлцэн тохиролцогч талуудад тэтгэвэр тогтоохтой холбоотой зохицуулалт нь хоёр улсын иргэдийн харилцан тэгш эрхтэй байдлыг тусгасан эсэх үнэлгээ

Хэлэлцээрт талуудын иргэдийн эрх тэгш байдлыг хангах зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэд, хамаарал бүхий хүмүүс болон тэжээгчээ алдагчдад Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү Хэлэлцэн тохиролцогч талын иргэний адил эрх тэгш хандахаар тусгасан байна.

Хэлэлцээрийн 14 дүгээр зүйлд бүрэн эрх бүхий этгээдүүдийн хамтын ажиллагаа, захиргааны дэмжлэгийн асуудлын хүрээнд Удирдлагын тохиролцоо байгуулахаар тусгасан нь хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад үүсгэх аливаа асуудлыг шийдэх, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн Хэлэлцээрийн 15 дугаар зүйлд Захиргааны болон эрх зүйн туслалцаа, 16 дугаар зүйлд Мэдээлэл хамгаалал, 17 дугаар зүйлд Төлбөр ба баталгаажуулалтаас чөлөөлөх, 18 дугаар зүйлд Өргөдөл, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг эрх тэгш авч үзэх, 19 дүгээр зүйлд Эмнэлгийн үзлэг, 20 дугаар зүйлд талуудын харилцах хэлийг найрийвчлан тусгасан нь хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх эерэг нөлөөтэй.

4/ Хэлэлцэн тохиролцогч талуудын хооронд хүний хувийн мэдээллийг дамжуулах, солилцох зохицуулалтын үнэлгээ

Хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохиролцогч талуудын нутаг дэвсгэрт шимтгэл төлсөн хугацааг иргэний өөрийн хүсэлтэд үндэслэн маягтуудын дагуу солилцох тул Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцэх юм.

Мөн хэлэлцээрийн 16 дугаар зүйлд Мэдээллийн хамгаалал нь хувь хүний нууцад хамаарах, мэдээллийг зөвхөн шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор хэлэлцэн тохиролцогч талууд хувь хүний мэдээллийг харилцан солилцож болно. Хувь хүний мэдээллийг харилцан солилцох болон боловсруулалт хийхдээ дотоодын холбогдох хууль тогтоомж болон мэдээлэл солилцож байгаа байгууллагуудын гаргасан нөхцөл шаардлагыг баримтлахаар зааж, талуудын улсын хууль тогтоомжийн хүрээнд ашиглахаар зохицуулсан.

3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

³ ОУХБ “ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл” УБ 2012, 330 дугаар тал

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23.1 дэх хэсэгт зааснаар тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээ хийлээ.

Хэлэлцээр нь нийтдээ 5 бүлэг, 26 зүйлтэй, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлага хангасан.
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зорчсон этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Шаардлага хангасан.
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Шаардлагагүй.

29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

4.“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг хавсаргав.

5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу хуулийн төслийн уялдаа холбоог дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасан Хуулийн төслийн уялдаа холбоог тогтооход тавих нийтлэг шаардлага	
<i>Шаардлага</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	-
4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	үгүй
4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	тийм
4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	үгүй
4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	үгүй
4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	үгүй
4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай

ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	үгүй
4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	тийм

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Дүгнэлт

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд, зорилт 1-ээс 4-ийг хангахад чиглэгдсэн зохицуулалтууд нь зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон байна.
- Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийхэд хуулийн төслийг ойлгомжтой болгох чиглэлээр санал ирүүлээгүй байна.
- Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.
- Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан.

--- оОо ---